



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 21-еедэр

Дугаар 4/228

Чингис хот

Г Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30.1.16, Захиргааны өрөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тусгасан үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмнөдэлгэр сумын цэцэрлэгийн эрхлэгч О.Ганцэцэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-13.7, Төсвийн тухай хуулийн 25.6-25.8, Төсвийн тухай хуулийн 47.1.1, 47.1.4, 47.2, Тамхины тухай хуулийн 9.1.6, 9.1.8 дахь заалтыг тус тус зөрчсөн нь шалгалтаар нотлогдсон тул Захиргааны өрөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийн дагуу сонсох ажиллагаа явуулах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Боловсрол, соёл, урлагийн газрын дарга С.Мөнхцэцэгийг томилсугай.
2. Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсонтой холбогдуулан хувийн ашиг сонирхолын зөрчлөөс ангид байж, төрийн ажил үйлчилгээг үнэнч шударгаар хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга С.Мөнхцэцэгт даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

